



СОЙЕМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨВ ЗҮТГЭЭ

№93 (93)

2021.07.19

ҮЙЛ ЯВДАЛ

МОНГОЛ ЦЭРГИЙН ТЭСВЭР ХАТУУЖЛЫГ ХАРУУЛСАН Э.ДАВААЖАМЦ ХОВДООС ДОРНОД ХҮРТЭЛ 2127 КМ ЗАМ ТУУЛЖ БАРИАНД ОРЛОО



Монголын ард түмэн, Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүн, түүний дотор ирэх жил 100 жилийн ойтойгоо золгох Ардын Хатанбаатараар овоглосон үе үеийн алба хаагчид бахархаж буй гэдэгт итгэл төгс байна.

Ахлах ахлагч Э.Даваажамцыг анхлан хүндэтгэлтэйгээр үдсэн Ховд аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, тус ангийн удирдлага, бие бүрэлдэхүүний төлөөлөлд мөн гүйлтийн явцад халдвар хамгааллын дэглэмийг сайтар сахисны үндсэн дээр угтах, хүндэтгэн үдэх ажлыг хэрэгжүүлсэн Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрийн цэргийн командлал, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Хэнтий, Дорнод аймаг болон Зэвсэгт хүчний 325, 339, 256, 232, 338, 327 дугаар ангийн удирдлага, бие бүрэлдэхүүний төлөөлөл, зарим төрийн ба төрийн бус байгууллагын ажилтнуудад чин сэтгэлийн талархал дэвшүүлье.

Анх гараанд гарсан эрчээрээ эх орныхоо баруун хязгаараас зүүн

Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн ахлах ахлагч Э.Даваажамц Монгол орны баруун хязгаар Ховд аймгаас гаран 46 хоногийн турш нийт 2127 км зайд гүйн өнөөдөр /2021.07.17/ 16.00 цагт Дорнод аймгийн Чойбалсан хотод ирлээ. Түүнийг Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн захирагч, хурандаа Н.Цэцэнхүү, Хуурай замын цэргийн командлалын тэргүүн ахлагч Д.Мөнхбаяр, Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн бие бүрэлдэхүүн болон Чойбалсан хотын иргэд барианд угтан авч хүндэтгэл үзүүллээ. Мөн түүнийг зорьсондоо хүрсэн явдалд нь Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч, хурандаа Х.Энхболд талархал дэвшүүлсэн байна.

Тэрээр энэхүү Талархалдаа: Юуны өмнө эрхэм ахлах ахлагч Таны амрыг эрж Цэргийн гавьяаны улаан тугийн одонт, Ардын Хатанбаатар С.Магсаржавын нэрэмжит Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн нийт бие бүрэлдэхүүний өмнөөс болон хувиасаа баяр хүргэн мэндчилье!

Монгол Улсын Зэвсэгт хүчин, цэрэг эрс маань эх орноо батлан хамгаалах нэн хариуцлагатай бөгөөд нэр хүндтэй үүргийг амжилттай гүйцэтгэхийн зэрэгцээ улс орны бүтээн байгуулалтад бодит хувь нэмрээ оруулж, эх орныхоо нэр хүндийг олон улсын тавцанд өндөрт өргөн эх дэлхийн энх тайван, амар амгаланг тогтоох үйлсэд хүчин зүтгэснээр тэдний мэргэжлийн ур чадвар, авхаалж самбаа, тэсвэр хатуужил, сахилга, зохион байгуулалт өсөн нэмэгдэж, олон улсын түвшинд Монгол цэрэг-

Дэлхийн цэрэг хэмээн үнэлэгдсээр байна.

Энэ цаг дор Ардын хувьсгалын болон орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ой, Ховд аймгийн 90, Цэргийн гавьяаны улаан тугийн одонт, Ардын Хатанбаатар С.Магсаржавын нэрэмжит Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн 100 жилийн ойд зориулан монгол цэргийн эр зориг, тэсвэр хатуужлыг илтгэн харуулж, Ховд аймгийн төвөөс Улаанбаатар хот, Дорнод аймгийн Чойбалсан хотын чиглэлд 2100 гаруй километр замыг өөрийн гүйлтээр туулж чадсан хөгжимчин ахлагчаараа бид бүхэн бахархаж байгаагаа илэрхийлье.

Тус ангийн захирагч, удирдлагын зүгээс хөгжимчин, ахлах ахлагч Э.Даваажамцынхаа бүтээлч санаачилгыг дэмжихийн зэрэгцээ энэ оны 2 дугаар сараас хойш тогтмол давтамжтайгаар идэвхтэй хийсэн бэлтгэлийн үр дүнг нь үнэлж, ЗХЖШ-ын дарга, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагчид илтгэн зөвшөөрөл авсны үндсэн дээр Ховд аймгийн төвөөс 6 дугаар сарын 2-ны өдөр анхны гараанд үдсэн нь саяхан мэт санагдана.

Энэ хугацаанд ахлах ахлагч Э.Даваажамц нь гүйлтийнхээ явцад анхлан төлөвлөсөн маршрутынхаа зай, хэмжээг нэмэгдүүлэн Дорнод аймгийн Чойбалсан хотын чиглэлд гүйх шийдвэрийг гаргасныг ч ЗХЖШ-ын удирдлага дэмжсэнд туйлын баяртай байна.

Цэргийн алба хаагч хэн бүхэн Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар, салаа, тасгийн бүрэлдэхүүнд 30 болон 10 км-ийн марш, 1000, 3000 метрийн гүйлтэд амжилт гарган оролцож чадах хэдий ч цор ганцаараа энэхүү хол замыг



бахархал дүүрэн туулж, өдөрт 50 км-ээс багагүй зайд тогтмол гүйж чадсан нь бие бялдар-сэтгэл зүйн өндөр хатуужилтай болохыг тань нотолсон баталгаа, нэр төрийн хэрэг юм.

Ийнхүү өөрийн эх оронд холын зайн гүйлтийн дээд амжилтыг тогтоохын хамт монгол хүмүүн, монгол цэргийн эр зориг, тэсвэр хатуужлыг иргэд, залуучууд, өсвөр үеийнхэнд сурталчлан өөрийн биеэр үлгэрлэн харуулсан эрхэм танаар

хязгаарын төв хүртэлх хол замыг амжилт дүүрэн туулж, өөрийн зорилгоо биелүүлж чадсан эрхэм Танд болон багийн бүрэлдэхүүнд дахин баяр хүргэж, амжилт бүхний дээдийг бэлгэдэн өрөөе.

Удахгүй Ховд аймгийн удирдлага, иргэд, залуучууд болон ангийн нийт бие бүрэлдэхүүнтэйгээ баяр бахдал дүүрэн уулзахын ерөөлийг айлтган дэвшүүлье!

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай" гэжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 24	☁️ 11

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	☁️ 20

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 35	☁️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.850.00	2.853.00
EUR 🇪🇺	3.380.00	3.395.00
CNY 🇨🇳	440.50	441.00
RUB 🇷🇺	37.20	39.40
JPY 🇯🇵	25.39	26.35
KRW 🇰🇷	2.40	2.56

ЗУРХАЙ

Аргын тооллын: 2021.07.19, Даваа гараг, Билгийн тооллын: 10, Хонгорцог одтой, шар луу өдөр

ЗУНЫ АДАГ ХӨХӨГЧИН ХОНЬ САРЫН ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАР ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Эрч хүч ихэснэ.

Наран ургах, шингэн:

05.13-20.44

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Нэр өнгө

Суудал:

Гал

Аргын тооллын 1 сарын 24, Бархасвадь гараг. Билгийн тооллын 19, Бага морь одтой, цагаагчин тахиа өдөр. Өдрийн наран 8 цаг 39 минутад мандан, 17 цаг 39 минутад жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адеуус муулах, угаал үйлдэх, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, гөлөг тэжээхэд муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсоод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрч, хүч нэмнэ.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 131.962 +1466	ЭДГЭРСЭН 130,612 +4730	НАС БАРСАН 734 +8
-----------------------------------	---------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 3848 +66	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 267 +230	ЭДГЭРСЭН 3514 +284
-----------------------------	---------------------------------	-----------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 190,280,826
Эдгэрсэн Нийт: 170,077,520
Нас барсан Нийт: 4,086,246



ХИЛИЙН ЧАНАДААС

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМААР ...



Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын "UNMISS" энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний 10 дугаар ээлжийн батальоны бие бүрэлдэхүүн Тулгар төрийн 2230, Их Монгол Улсын, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, Ардын Хувьсгалын 100 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэхийн зэрэгцээ тус ээлжийн батальоны бие бүрэлдэхүүнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын медаль хүртээх ёслолын ажиллагааг зохион байгууллаа.

Энэхүү ёслолд "UNMISS" ажиллагааны хүчний командлагчийн орлогч, хошууч генерал МД Майн Уллах

Човдхури, Юнити секторын командлагч МД Шамим Камал, Жуба секторын бригадын генерал Б.Эрдэнэбат, "UNMISS" энхийг сахиулах ажиллагааны үндэсний ахлах төлөөлөгч, Өмнөд секторын штабын дарга, хурандаа Ж.Молорболд болон "UNMISS" ажиллагааны хүчний командлагч, Юнити секторын штаб, НҮБ-ын ажиглагч офицерууд, гадаадын цэргийн багуудын удирдлага, бусад зочид оролцлоо.

Энэ үеэр "Дээлтэй Монгол" бие бүрэлдэхүүний жагсаал, Монгол үндэсний ёс заншлын болон урлаг, соёлын сонирхолтой үзүүлбэрүүд, хүчит бөхийн барилдаан, үндэсний шагайн харваа, хурдан морь уралдуулах шагайн наадгай зэрэг ёслол хүндэтгэлийн

ажиллагааг зохион байгуулж, хүндэт зочид, наадамчин олноо баясгав.

Хүчит бөхийн барилдаанд аймаг, сумын цолтой 64 бөх зодоглож, аймгийн харцага, дэд ахлагч Э.Ширнэн түрүүлж, сумын заан ахлах ахлагч С.Эрхэмбаяр үзүүлсэн бөгөөд сумын заан дэд ахлагч Э.Бүүвэйжаргал, сумын заан дэд ахлагч Х.Эрдэнэбат нар шөвгөрлөө.

Мөн үндэсний шагайн харвааны тэмцээнд штаб, салбарын 7 баг цэц мэргэнээ сорьсноос ахлах ахлагч О.Азбаяр ахлагчтай баг тэргүүлж, дэд байрт ахлах ахлагч Д.Ганхавх ахлагчтай баг, удаах байрт дэслэгч Ц.Түмэнжаргал ахлагчтай баг удааллаа.

Ахлах дэслэгч Г.ЦЭРЭННАДМИД

32 ХУЧИТ БӨХИЙН БАРИЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 326 дугаар анги

Ардын хувьсгалын 100 жилийн ойн баяр наадмыг тохиолдуулан Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн Зенитийн артиллерийн дивизионы хугацаат цэргийн алба хаагчидтай зохион байгуулах баяр амралтын өдрийн төлөвлөгөөний дагуу "32 хүчит бөхийн барилдаан", "Хурдан дайчдын уралдаан", "Сурын харваа" тэмцээнийг амжилттай зохион байгуулж явууллаа. Алба хаагчид маань үндэсний өв соёлоороо бахархсан, бие биеэсээ суралцсан ололт амжилтаар дүүрэн наадамлав.

АХЛАХ АХЛАГЧ Э.ДАВААЖАМЦЫГ ХҮЛЭЭН АВЧ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ

Зэвсэгт хүчний 338 дугаар анги

Ховд аймгийн Буянт сумын харьяат, Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хөгжмийн салааны хөгжимчин, ахлах ахлагч Э.Даваажамц Ховд хотоос Улаанбаатар хот хүртэл 1500 км зайд гүйхээр 6 дугаар сарын 2-ны өдөр гарч "Монгол Улсын Төрийн далбааны өдөр" буюу 7 дугаар сарын 10-ны өдөр барианд орохоор төлөвлөн гүйсэн ч дэлхийн нийтэд дэгдээд байгаа "Аюулт өвчин"-ий улмаас төлөвлөгөө өөрчлөгдөж, бариагаа Дорнод аймгийн төв Чойбалсан хотод хийхээр гүйж байгаа билээ. Тэрээр хоногт

60-65 км замыг туулан гүйсээр өнөөдөр /2021.07.12/-ийн 11.20 цагийн орчимд анхны гараанаас 1827, Улаанбаатараас 360, Чингисхаан хотоос 30 дахь км-т буудаллах үед Сүхбаатар аймаг дахь хурандаа П.Мөнхбат захирагчтай Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн удирдлага, хамт олны төлөөлөл угтан авч, хүндэтгэл үзүүлээ.

Ахлах ахлагч Э.Даваажамц нь санаачлан хийж байгаа Монгол цэргийн эр зориг, тэсвэр хатуужлын бахархалт үйлсээрээ төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын төдийгүй хүүхэд, залуучуудын дунд үлгэрлэл, манлайлал

болон тодорч байгаа шинэ үеийн залуучуудын төлөөлөл билээ. Ахлах ахлагч Э.Даваажамцдаа энэхүү гайхамшигт үйлсээрээ олон олон залуусыг уриалан манлайлж, цэрэг эх оронч үзлийг хүүхэд залууст төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулж, бариандаа амжилттай хүрэх алтан шар зам тань өлзийтэй байхыг хүсье. Мөн Танд ажил албандаа өндөр амжилт гарган, өсөж дэвшиж байхыг, амьдрал нь эрүүл энх, аз жаргал, хорвоогийн хамгийн сайн сайхан бүхнийг Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн удирдлага, хамт олны зүгээс хүсэн ерөөе. Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай.

ЦЭРГИЙН ТАНГАРАГ ДАВТАХ, АХМАД ДАЙЧИНД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 327 дугаар анги

Тулгар Төрийн 2230 жил, Их Монгол Улсын 815, Ардын Хувьсгалын 100 жилийн ойн баярын хүрээнд Цэргийн тангараг давтаж, Цэргийн алба хаасны тэтгэвэрт гарч байгаа салааны ахлагч, бэлтгэл ахлах ахлагч С.Батзориг Байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион

байгууллаа. Бэлтгэл ахлах ахлагч С.Батзориг бие бүрэлдэхүүнд хандаж гар, сэтгэл нийлж ажилласан хамт олондоо баярлалаа, та бүхнийхээ эх орноо батлан хамгаалах их үйлсэд өндөр амжилт хүсье гэсэн юм. Үүний дараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар "Цэргийн хүндэт" медалиар бэлтгэл ахлах ахлагч С.Батзориг, ахлах ахлагч Б.Амарбаатар, ахлах ахлагч

Ш.Батсүх нар шагнагдсан бол Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн медаль, ЗХЖШ-ын даргын тушаалаар Цэргийн холбоо үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн "Дурсгалын медаль", ангийн захирагчийн тушаалаар албан тушаалын зэрэглэлийн дагуу ахлах ахлагч, ахлагч, дэд түрүүч, ахлах байлдагч цолоор шагнаж урамшууллаа.

"ҮСЭГЛЭЛИЙН ХААД"-ЫГ ТОДРУУЛАВ



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

Үндэсний их баяр наадмын амралтын өдрүүдээр нэгтгэлийн Хугацаат цэргийн алба хаагчдын амралт чөлөөт цагийн зөв боловсон өнгөрөөх үүднээс "Үндэсний баяр наадмын сэдэвтэй хошин зохиомжийн тэмцээн зохион байгуулж явууллаа. Тэмцээнд нийт 5 баг оролцсон бөгөөд багууд үндэсний баяр наадмын сэдэвтэй хошин зохиомжийг 5 минутын хугацаанд хийж гүйцэтгэв. Тухайлбал, "Монгол ээтэн" баг нь үндэсний соёл

болон монгол ардын дууг хөгжилтэй хошин хэв маягт оруулсан зохиомж үзүүлсэн бол "Их цэргийн хүрээ" баг нь гитар ашиглаж үндэсний язгуур урлаг болох хөөмийг хослуулан цэргийн хүрээний харчуул гэсэн сэдэвтэй зохиомж үзүүллээ. Удаах "Монгол баатар" баг нь цэргийн албанд ирээд баяр амралт хэрхэн өнгөрөөдөг зугаатай байдаг өөрийн хөгжилтэй түүхийг харуулж чадсан бол "Танкистууд" баг нь эрийн гурван наадам харуулсан дуу шүлэг магтаал уншиж мэндчилгээ дэвшүүллээ. Мөн "Гоолингоо" баг нь зохиолын дуун дээр жүжигчилсэн тоглолт хийж үзүүлснээс "Монгол

ээтэн" баг нь үндэсний соёл болох монгол ардын дууг хөгжилтэй хошин хэв маягт оруулсан зохиомж үзүүлснээрээ бусдыгаа манлайлав. Үргэлжлүүлээд "Үсэглэлийн хаад" тэмцээн зохион байгуулсан бөгөөд байлдагч М.Сугирсүрэн нэгдүгээр байр эзэлж үнэ бүхий зүйлээр шагнуулав. Мөн нэгтгэлийн биен тамирын талбайд "Гэдэс таталт"-ын тэмцээн зохион байгуулж явууллаа. Тэмцээнд нийт 9 цэргийн алба хаагчид оролцсоноос байлдагч М.Азбаяр 75 удаа гэдэс таталт хийж бусдыгаа хошуучиллаа.

Дэслэгч Ц.БАДАМСҮРЭН